

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 7570 дугаарт бүртгэв

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 3 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар А/84

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Усан замын тээврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 119 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Оюунтуяа)-т, журмыг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Далайн захиргаа (М.Өлзий)-нд, орон нутгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 119 дүгээр тушаалыг бүхэлд нь хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2026 оны 3 дугаар сарын
23-ны өдрийн А/84 дүгээр тушаалын хавсралт*

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ХИЙХ, ТОО БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, УЛСЫН ДУГААР ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь усан замын тээврийн үйл ажиллагааг гол, мөрөн, нуур тэдгээрийн байгаль, экологи, сөрөг нөлөөгүй эрхлэхэд төрийн хяналт, зохицуулалтыг чиглүүлж, хүн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг, оношилгоо хийх, хөвөлтийн аюулгүй байдлыг хангасан, усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар, гэрчилгээ олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг эрх олгогдсон улсын ахлах байцаагч болон улсын байцаагч энэхүү журамд нийцүүлэн зохион байгуулж, “Усан замын тээврийн хэрэгслийн техникийн үзлэг, оношлогооны хуудас” (журмын 4 дүгээр хавсралт)-ыг хөтөлнө.

1.3.Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон улсын дугаар олгох үйл ажиллагааг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллага (цаашид “бүртгэлийн байгууллага” гэх) эрхлэн гүйцэтгэх бөгөөд усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлж, лавлагаа гаргана.

1.4.Усан замын тээврийн хэрэгслээс үүдэлтэй осол, зөрчил гарсан тохиолдолд бүртгэлийн байгууллагаас мэргэжлийн ажилтан, шинжээчээр ажиллаж болно.

1.5.Энэхүү журмын хэрэгжилтийг бүртгэлийн байгууллага зохион байгуулж, усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

Хоёр.Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх

2.1.Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг (цаашид “техникийн хяналтын үзлэг” гэх)-ийг жилд нэг удаа бүртгэлийн байгууллагаас үзлэг оношилгоо, утааны найрлага болон бусад үзүүлэлтийг зориулалтын багаж хэрэгслээр хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд ээлжит бус үзлэг хийж болно.

2.2.Техникийн хяналтын үзлэгийг жил бүрийн хөвөлтийн улирал эхэлснээс хойш 14 хоногийн дотор хийнэ.

2.3.Техникийн хяналтын үзлэгт оруулах усан замын тээврийн хэрэгсэлд Усан замын тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан даатгалыг заавал хийлгэсэн байна.

2.4.Техникийн хяналтын үзлэгээр усан замын тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, хөдөлгүүрийн дугаар, төрөл, зориулалтыг усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээнд заасан мэдээлэлтэй тулгаж, хянах ба зайлшгүй шаардагдах нэмэлт хэрэгслийн /галын хор, ослын дохио, уяа оосор, эмийн сан/ бүрдэл, ашиглалтын шаардлага зэргийг шалгана.

2.5.Техникийн хяналтын үзлэгээр усан замын тээврийн хэрэгсэл нь техникийн дараах шаардлагыг хангаж буй эсэхийг шалгана. Үүнд:

2.5.1.хөдөлгүүрийн ажиллагаа;

2.5.2.их биеийн бүрэн бүтэн байдал (цоорсон, цуурсан, элэгдсэн эсэх);

2.5.3.гэрлэн ба дуут дохионы хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдал;

2.5.4.ус шавхагч насос хэвийн ажиллагаатай эсэх;

2.5.5.жолоодлогын тоног төхөөрөмж хэвийн ажиллагаатай эсэх;

2.5.6.бусад аврах хэрэгсэл шаардлага хангаж байгаа эсэх;

2.5.7.аврах хантааз нь стандартын болон ашиглалтын шаардлага бүрэн хангаж, зорчигчдын суудлын тоонд хүрэлцэхүйц хэмжээнд байгаа эсэх /хүүхдэд болон том хүнд зориулсан/;

2.5.8.шатахууны савны битүүмжлэл, шатах тослох материал алдагдаж буй эсэх;

2.5.9.хөдөлгүүрээс ялгарч буй утааны бохирдол байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэх;

2.5.10.хөдөлгүүрийн багтаамж, хүчин чадал нь усан замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн тодорхойлолтод нийцсэн эсэх;

2.5.11.цахилгааны тоног төхөөрөмж, холбооны хэрэгслүүдийн хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдал.

2.6.Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийлгэхэд дараах баримт бичиг бүрдүүлнэ. Үүнд:

2.6.1.иргэн бол иргэний үнэмлэх, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ болон түүнтэй адилтгах цахим лавлагаа;

2.6.2.усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ, хувийн хэрэг, бусад дагалдах баримт бичиг;

2.6.3.усан замын тээврийн хэрэгсэлд их засвар хийсэн бол хувийн хэрэгт тэмдэглэсэн байх;

2.6.4.усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч солигдсон буюу бусад тохиолдолд хийгдсэн шилжилтийн тухай баримт бичиг;

2.6.5.даатгалд даатгуулсан баримт бичиг;

2.6.6.техникийн хяналтын үзлэгийн төлбөр төлсөн баримт.

2.7.Ээлжит бус техникийн хяналтын үзлэгийг дараах тохиолдолд хийнэ. Үүнд:

2.7.1.техникийн хяналтын үзлэгт хамрагдсан усан замын тээврийн хэрэгсэлд зайлшгүй шаардлагаар их засвар үйлчилгээ хийлгэж, хөдөлгүүр сольсон;

2.7.2.байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүссэн болон хөвөлтийн аюулгүй байдлын шаардлага хангахгүй байгаа талаар иргэдээс санал, гомдол гаргасан;

2.7.3.ашиглагдаж байгаа импортоор оруулж ирсэн усан замын тээврийн хэрэгсэлд.

2.8.Техникийн хяналтын үзлэгт тэнцсэн усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг оношилгооны хуудсанд тухайн техникийн хяналтын үзлэгийг хийсэн улсын байцаагч гарын үсэг зурж баталгаажуулна.

2.9.Эвдрэл, гэмтлийн улмаас хөвөлтөд гарах боломжгүй усан замын тээврийн хэрэгслийг өмчлөгч, эзэмшигч нь бүртгүүлж, гэрчилгээнд болон хувийн хэрэгт энэ тухай тэмдэглэл хийлгүүлнэ.

2.10.Эвдрэл, гэмтэл болон бусад шалтгаанаар цаашид ашиглах боломжгүй болсон усан замын тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглосон тухай тэмдэглэгээг гэрчилгээний “тусгай тэмдэглэл” хэсэгт хийж, энэ журмын 6.1, 6.2 дахь заалтыг үндэслэн бүртгэлээс хасалт хийн гэрчилгээг хураан авна.

2.11.Хөвөлтийн бус хугацаанд буюу хүйтний улиралд импортоор оруулж ирсэн усан замын тээврийн хэрэгслийг анхан шатны үзлэгт хамруулж болох ба техникийн хяналтын үзлэгийн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Өмчлөгч нь анхан шатны үзлэгт хамрагдсан усан замын тээврийн хэрэгслийг тухайн жилийн ээлжит техникийн хяналтын үзлэгт энэ журмын 2.2-т заасан хугацаанд хамруулах үүрэгтэй бөгөөд энэ тохиолдолд журмын 2.12-т зааснаас бусад техникийн шаардлага хангасан эсэхийг шалгана.

2.12.Анхан шатны үзлэгээр усан замын тээврийн хэрэгслийн техникийн паспорт, үйлдвэрлэгчийн дагалдах баримт бичигт заасан мэдээлэлтэй нийцэж буй эсэх, аврах хэрэгслийн бүрдэл, ашиглалтын шаардлага хангаж буй эсэхийг шалгана.

Гурав.Усан замын тээврийн хэрэгслийг бүртгэх, улсын дугаар, гэрчилгээ олгох

3.1.Үзлэг оношилгоонд хамрагдсан усан замын тээврийн хэрэгслийг өмчлөгчийн хаягаар бүртгэж, улсын дугаар, гэрчилгээ олгоно.

3.2.Өмчлөгч нь улсын дугаараас гадна усан замын тээврийн хэрэгсэлдээ нэр өгөх хүсэлт гаргасан бол, түүний санал болгосон нэрийг бусад усан замын тээврийн хэрэгсэлд олгосон нэртэй давхардуулахгүй олгож, тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон хувийн хэрэгт тэмдэглэнэ.

3.3.Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээг баталсан загвар (журмын 1 дүгээр хавсралт)-ын дагуу нууцлалын шаардлагыг хангаж хэвлүүлнэ.

3.4.Усан замын тээврийн хэрэгсэл өмчлөгч нь тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэрэг (журмын 2 дугаар хавсралт) хөтлөх бөгөөд хувийн хэргийг батлагдсан загварын дагуу бүртгэлийн байгууллагаас олгоно.

3.5.Усан замын тээврийн хэрэгслийг 14 хоногийн дотор улсын бүртгэлд шинээр бүртгүүлэх ба дараах баримт бичгийг бүрдүүлж, бүртгэлийн байгууллагад ирүүлнэ. Үүнд:

3.5.1.өмчлөгч нь иргэн бол иргэний үнэмлэх, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн цахим лавлагаа, өргөдлийн маягт (журмын 5 дугаар хавсралт), эрх бүхий этгээдийн шийдвэр, албан хүсэлт;

3.5.2.усан замын тээврийн хэрэгслийн техникийн паспорт, үйлдвэрлэгчийн дагалдах баримт бичиг;

3.5.3.импортоор оруулж ирсэн бол гаалийн бүрдүүлэлт хийснийг нотолсон баримт бичиг, эсхүл гаалийн байгууллагын тодорхойлолт;

3.5.4.усан замын тээврийн хэрэгслийг Монгол Улсад үйлдвэрлэж, угсарсан бол түүний аюулгүй байдлыг хянан баталгаажуулсан гаднын мэргэжлийн байгууллагын баримт бичиг, оюуны өмчийн газарт бүртгүүлж, патентийн гэрчилгээ авсан байх;

3.5.5.усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг, оношилгоо хийсэн хуудас;

3.5.6.улсын тэмдэгтийн хураамж болон гэрчилгээний үнэ төлсөн баримт;

3.5.7.Усан замын тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан даатгалын баримт бичиг;

3.5.8.Иргэний хуульд заасан өмчлөх эрх шилжүүлэх бүх төрлийн гэрээ, нотариатаар гэрчлүүлсэн байх.

Дөрөв.Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийх

4.1.Дараах тохиолдолд усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэлд шилжилт хөдөлгөөн, өөрчлөлтийг хийлгэнэ. Үүнд:

4.1.1.өмчлөгч хүн, хуулийн этгээд нь усан замын тээврийн хэрэгслээ бусдад худалдах, бэлэглэх, солилцох, шилжүүлэх;

4.1.2.өмчлөгч хүн, хуулийн этгээдийн оршин байгаа байршил, хаяг өөрчлөгдөх;

4.1.3.усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг өөрчлөх;
4.1.4.өмчлөгч хуулийн этгээд татан буугдсан, улсын бүртгэлээс хасагдсан эсхүл өмчлөгч нас барсан;

4.1.5.усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч нас барсан тохиолдолд өв залгамжлагчийн, мөн шүүхийн шийдвэрээр усан замын тээврийн хэрэгслийг хураасан буюу шилжүүлсэн бол шийдвэрт заасан хүн, хуулийн этгээдийн нэр дээр бүртгэх;

4.1.6.татан буугдаж бүртгэлээс хасагдсан хуулийн этгээдийн усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлийн лавлагаа, албан хүсэлтийг үндэслэн бусад хүн, хуулийн этгээдийн нэр дээр бүртгэх.

4.2.Иргэн шилжилт хөдөлгөөнийг бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

4.2.1.иргэний үнэмлэхийн хуулбар эсхүл түүнтэй адилтгах цахим лавлагаа;

4.2.2.баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;

4.2.3.усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ;

4.2.4.Иргэний хуульд заасан өмчлөх эрх шилжүүлэх бүх төрлийн гэрээ, нотариатаар гэрчлүүлсэн байх;

4.2.5.Усан замын тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан даатгалын баримт бичиг.

4.3.Хуулийн этгээд шилжилт хөдөлгөөнийг бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

4.3.1.эрх бүхий этгээдийн шийдвэр, албан хүсэлт;

4.3.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим лавлагаа;

4.3.3.Энэ журмын 4.2.3-4.2.5-д заасан баримт бичиг.

4.4.Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг өөрчилсөн бол тухайн өөрчлөлт нь стандартын шаардлага хангаж байгааг нотолсон техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт, өмчлөгчийн хүсэлтийг үндэслэн өөрчлөлтийг бүртгэж, гэрчилгээнд тэмдэглэнэ.

4.5.Өмчлөгч хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасагдсан шийдвэр, татан буулгах тухай шийдвэр, хүсэлт, улсын бүртгэлийн цахим лавлагааг үндэслэн шилжилт хөдөлгөөнийг бүртгэнэ.

Тав.Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөн олгох

5.1.Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээг үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн авахын тулд дараах баримт бичгийг бүрдүүлж, бүртгэлийн байгууллагад ирүүлнэ. Үүнд:

5.1.1.үрэгдүүлсэн гэрчилгээг нөхөн олгохыг хүссэн өмчлөгчийн өргөдөл, хуулийн этгээд бол албан бичиг;

5.1.2.гэрчилгээг үрэгдүүлсэн тухай зарын хуулбар;

5.1.3.гэрчилгээний үнэ тушаасан баримт.

5.2.Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөж олгосон

тохиолдолд гэрчилгээ дээр “нөхөн олгов” гэж тэмдэглэнэ.

5.3.Хэрэглээний явцад хуучирч муудсан, бичлэг тэмдэглэл нь баларч уншигдах боломжгүй болсон гэрчилгээг хураан авч, өмчлөгчийн хүсэлтээр үнийг нь төлүүлэн сольж болно.

Зургаа.Усан замын тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах

6.1.Усан замын тээврийн хэрэгслийг техникийн хувьд цаашид ашиглах боломжгүй болсон эсхүл усанд живсэн, экспортлох тохиолдолд өмчлөгч хүн, хуулийн этгээд усан замын тээврийн хэрэгслээ нэг сарын дотор улсын бүртгэлээс хасуулна.

6.2.Усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулах тохиолдолд дараах баримт бичгийг бүрдүүлж, бүртгэлийн байгууллагад ирүүлнэ. Үүнд:

6.2.1.усан замын тээврийн хэрэгслийг техникийн хувьд цаашид ашиглах боломжгүй болсон, эсхүл экспортлох бол улсын бүртгэлээс хасуулах тухай өмчлөгч хүн, хуулийн этгээдийн хүсэлт, шийдвэр;

6.2.2.Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ;

6.2.3.техникийн хяналтын үзлэг хийсэн улсын байцаагчийн акт, эсхүл усанд живсэн тухай онцгой байдлын байцаагчийн дүгнэлт.

6.3.Бүртгэлийн байгууллага нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хасалт хийнэ.

Тайлбар: Бүртгэлийн байгууллага нь энэхүү журмын 2.6.1, 2.6.2, 2.6.4, 3.5.1, 3.5.5, 4.2.1, 4.3.2, 6.2.2 дахь заалтад заасан баримт бичгүүдийг төрийн цахим системээс татан авах нөхцөл бүрдсэн тохиолдолд иргэн хуулийн, этгээдээс шаардахгүй.

Долоо.Усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгчийн эрх, үүрэг

7.1.Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг солих буюу их засвар хийсэн тохиолдолд, мөн өмчилж авснаас хойш 14 хоногийн дотор бүртгэлийн байгууллагад бүртгүүлж улсын дугаар, гэрчилгээ авах буюу шилжилт хөдөлгөөн хийлгүүлнэ.

7.2.Усан замын тээврийн хэрэгслийн улсын дугаарыг баталсан загвар (журмын 3 дугаар хавсралт)-ын дагуу байршуулж тэмдэглэнэ.

7.3.Усан замын тээврийн хэрэгслийг техникийн хувьд бүрэн бүтэн ашиглах ба түүний техникийн байдалд тогтмол үзлэг хийж, илэрсэн эвдрэл, гэмтлийг тухай бүр засах, өнгө үзэмжийг сайжруулах, тээврийн хэрэгсэлд засвар, үйлчилгээ хийсэн талаарх тэмдэглэгээг хувийн хэрэгт хийнэ.

7.4.Хяналтын улсын (ахлах) байцаагчийн тавьсан шаардлагыг бүрэн биелүүлж, усан замын тээврийн хэрэгслээ товлогдсон хугацаанд техникийн хяналтын үзлэгт заавал хамруулна.

7.5.Тээврийн хэрэгслийн зориулалтыг өөрчилсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Найм.Бүртгэлийн байгууллагын эрх, үүрэг

8.1.Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар, гэрчилгээ олгох, шилжилт хөдөлгөөн хийх, бүртгэлээс хасах үйл ажиллагаа зохион байгуулна.

8.2.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн тээврийн хэрэгсэлтэй холбоотой хүсэлт, холбогдох материалыг хүлээж авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэнэ.

8.3.Усан замын тээврийн хэрэгслийг бүртгэж, гэрчилгээ олгохдоо бүртгэлийн карт хөтөлнө.

8.4.Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, шилжилт хөдөлгөөн хийлгэх, бүртгэлээс хасах талаар энэхүү журмын заалтыг зөрчсөн тохиолдолд түүнийг арилгуулах арга хэмжээ авна.

8.5.Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх хугацаа болон хамрагдах нутаг дэвсгэр, байршлыг өдөр тутмын сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр уг үзлэг явуулахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө олон нийтэд урьдчилан мэдээлнэ.

8.6.Усан замын тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт бүрэн хамруулах ажлын бэлтгэлийг хангах, арга хэмжээг авах талаар тухайн орон нутгийн холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

8.7.Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой үйлчилгээг цахим хэлбэрээр авах нөхцөлийг бүрдүүлнэ.

Ес.Усан замын тээврийн улсын (ахлах) байцаагчийн эрх, үүрэг

9.1.Усан замын тээврийн хяналтын улсын (ахлах) байцаагч нь батлагдсан хуудсыг баримтлан тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоог хийнэ.

9.2.Үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгсэл нь техникийн хяналтын шаардлагыг хангаагүй тохиолдолд өмчлөгчид доголдол, дутагдлыг арилгах талаар хугацаатай үүрэг өгч дахин үзлэг хийлгэх арга хэмжээг авна.

9.3.Үзлэгээр илэрсэн доголдол, дутагдлыг арилгаагүй болон үзлэгт оруулаагүй тээврийн хэрэгслийг усан замын хөдөлгөөнд оролцуулахгүй буюу шаардлагатай гэж үзвэл түр саатуулах, мөн холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна.

9.4.Техникийн хяналтын үзлэгийн үр дүнг үндэслэн усан замын тээврийн хэрэгслийн зориулалт, хүчин чадалд нийцүүлсэн аялах бүсийн хязгаарлалтыг тодорхойлж хувийн хэрэгт тэмдэглэнэ.

9.5.Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийхдээ нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, норм, норматив, стандартыг мөрдөж ажиллах бөгөөд хууль тогтоомжид заасан улсын байцаагчийн бүрэн эрхийн дагуу хяналтыг хэрэгжүүлнэ.

Арав.Мэдээллийн сан бүрдүүлэх болон цахим үйлчилгээ

10.1.Мэдээллийн сан нь бүртгэлийн эх баримт бичиг бүхий архив, цахим мэдээллийн сангаас бүрдэх бөгөөд мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглахдаа эрх бүхий байгууллагаас гаргасан төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохицуулсан журам, зааврыг мөрдлөг болгоно.

10.2.Өмчлөгч нь төрийн нэгдсэн үйлчилгээний систем болон бүртгэлийн байгууллагын цахим системээр дамжуулан цахим үйлчилгээг авна.

10.3.Цахим үйлчилгээ авахдаа энэхүү журамд заасан шаардагдах баримт бичгийн бүрдлийг бүрэн хангасан байх ба төрийн цахим үйлчилгээний мэдээллийн санд бүртгэлтэй баримт бичгийг бүрдүүлэхгүй байж болно.

10.4.Мэдээллийн санд тээврийн хэрэгслийн улсын дугаар, оноосон нэр, марк, зориулалт, үйлдвэрлэсэн он, үйлдвэрлэсэн улс, даац, урт, өргөн, суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадал, хөдөлгүүрийн дугаар, өмчлөгчийн мэдээлэл, цахим гэрчилгээний мэдээллийг кирилл болон латин үсгээр бүртгэнэ.

10.5.Цахим хүсэлт нь Цахим гарын үсгийн тухай хуулийн шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд иргэн, хуулийн этгээдийн санаатай болон болгоомжгүй байдлаас үүссэн аливаа эрсдэлийг бүртгэлийн байгууллага хариуцахгүй болно.

Арван нэг.Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага


11.1.Усан замын тээврийн тухай хууль болон энэхүү журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Арван хоёр.Бусад

12.1.Улсын хилээр түр хугацаагаар буцаж гаргах нөхцөлөөр оруулсан усан замын тээврийн хэрэгслүүдэд “түр дугаар” олгож бүртгэлийн байгууллагаас бүртгэл хөтөлнө.

Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын нэгдүгээр хавсралт

Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээний нүүр тал
(арын дээсгэр өнгө хөх цэнхэр байх ба соёмбо байрлуулна)

	<p align="center">САНАМЖ</p> <p>Усан замын тээврийн хэрэгсэл өмчлөгч Т.А. Шинээр усан замын тээврийн хэрэгсэл өмчижи авсан бол 14 хоногийн дотор бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, гэрчилгээ, улсын дугаар авна.</p> <p>Тухайн усан замын тээврийн хэрэгсэлээ ашиглалтаас хассан бол 14 хоног дотор бүртгэлийн байгууллагад хандаж хэсэлт хийлгэнэ.</p> <p>Өмчлөгчийн нэр, хаяг, усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөр өөрчлөгдсөн бол 14 хоногийн дотор энэ тухай бүртгэлийн байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.</p> <p>Усан замын тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй бол хөвөлтөд гарахыг хориглоно.</p>	<p align="center">МОНГОЛ УЛС</p>  <p align="center">УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРГЭСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ (MGL)</p> <p align="center">Дугаар №</p>																					
<p>Усан замын тээврийн хэрэгслийн ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ</p> <p>Улсын дугаар _____ Нэр _____ Марк _____ Ангилал _____ Зориулалт _____ Үйлдвэрлэсэн он _____ Улс _____ Даац _____ урт _____ Зорчигчдын багтаалж _____ Хөдөлгөөр, багтаалж, _____ дугаар _____</p> <p>Монгол Улсад оруулж ирсэн өнөө _____ Гэрчилгээ олгосон: _____ /гарын үсэг/ /гэмдэг/ 20... оны ... сарын ...-ны өдөр</p>	<p align="center">(MGL)</p> <p>Өмчлөгч, эзэмшч ирсэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр _____ Хаяг _____</p> <p align="center">Өөрчлөгдсөн тэмдэглэл</p> <p>Хаяг _____ 20... оны ... сарын ...-ны өдөр</p> <p align="center">Өөрчилсөн тэмдэглэл</p> <p>Хөдөлгөөр, багтаалж, дугаар _____ /гэмдэг/ _____ /гарын үсэг/ 20... оны ... сарын ...-ны өдөр</p>	<p align="center">ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН ТЭМДЭГЛЭЛ</p> <table border="1"> <tr> <td>Он, сар, өдөр</td> <td>Техникийн багдал</td> <td>Гарын үсэг /гэмдэг/</td> </tr> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> </table> <p align="center">Тусгай тэмдэглэл (засаартай бол хүчингүй)</p> <p>_____</p>	Он, сар, өдөр	Техникийн багдал	Гарын үсэг /гэмдэг/																		
Он, сар, өдөр	Техникийн багдал	Гарын үсэг /гэмдэг/																					

*Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх,
тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын хоёрдугаар
хавсралт*

/Нүүр хэсэг/

**УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН
ТЕХНИК АШИГЛАЛТЫН
ХУВИЙН ХЭРЭГ**

№

АГУУЛГА

- 1.Ерөнхий мэдээлэл, техникийн тодорхойлолт
- 2.Өмчлөгч солигдсон тухай тэмдэглэл
- 3.Хөдөлгүүр солигдсон тухай тэмдэглэл
- 4.Ангиллаас нь хамааруулан усан замын тээврийн хэрэгсэлд заавал байх шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслүүд
- 5.Ажлын гүйцэтгэл
- 6.Техникийн оношилгоо, засвар үйлчилгээ хийсэн тэмдэглэл
- 7.Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тухай тэмдэглэл
- 8.Хувийн хэрэг хөтлөлтийг шалгасан тэмдэглэл
- 9.Ерөнхий мэдээллийн бүртгэл, өөрчлөлт

Харьяаллын аймаг, хот _____
Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн _____
Үйл ажиллагаа эрхлэх бүс нутаг _____

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	ТЭМДЭГЛЭЛ
1	Гэрчилгээний дугаар	
2	Улсын дугаар	
3	Оноосон нэр	
4	Зориулалт	
5	Марк	
6	Үйлдвэрлэсэн он, улс	
7	Импортоор орж ирсэн огноо	
8	Ангилал	
9	Зорчигчийн суудлын багтаамж	
10	Их биеийн материал	
11	Их биеийн урт, өргөн /метр/	
12	Даац	
13	Хажуу хавирганы нийт өндөр, уснаас дээших өндөр	
14	Багийн бүрэлдэхүүний тоо	
	ХӨДӨЛГҮҮРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
15	Хөдөлгүүрийн төрөл	
16	Хүчин чадал /м.хүч/	
17	Хөдөлгүүрийн дугаар	
18	Хөдөлгүүрийн такт	

Хувийн хэрэг нээж, бүртгэсэн:

/гарын үсэг/

/албан тушаал/

ХОЁР.ӨМЧЛӨГЧ СОЛИГДСОН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

№	Огноо	Шалтгаан	Хүлээлгэн өгсөн	Хүлээн авсан
1.				
2.				
3				

ГУРАВ.ХӨДӨЛГҮҮР СОЛИГДСОН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

№	Огноо	Төрөл	Хүчин чадал	Үйлдвэрийн дугаар	Улсын байцаагч /гарын үсэг, тэмдэг/
1.					
2.					
3...					

ДӨРӨВ.АНГИЛЛААС НЬ ХАМААРУУЛАН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ЗААВАЛ БАЙХ ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ХЭРЭГСЛҮҮД

№	Багаж, тоноглолын нэр	Тоо ширхэг
1	Дохионы хэрэгслүүд	
2	Аврах хэрэгслүүд	
3	Холбооны техник хэрэгслүүд	
4	Навигацийн тоног төхөөрөмж	
5	Гал унтраах хэрэгслүүд	
6	Зангуу, уяа оосрууд	
7	Хангалтын бусад хэрэгслүүд /анхан шатны тусламж/	
8	Бусад	

ТАВ.АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

..... ОГНОО

Үзүүлэлт	Хөвөлтийн хугацааг				Нийт дүн
		VI	VII	VIII	
Зорчигч тээвэр	Зорчигч эргэлт				
	Тээвэрлэсэн зорчигч /хүн/				
Ачаа тээвэр	Ачаа эргэлт /тн.км-ээр/				
	Тээсэн ачаа				
Хөдөлгүүрийн ажилласан цаг /мот/цаг/					
Үүнээс	Ачаатай				
	Хүнтэй				
Зарцуулсан	Шатахуун /литр/				
	Хөдөлгүүрийн тос /литр/				

ЗУРГАА.ТЕХНИКИЙН ОНОШИЛГОО, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ

/Урсгал засвар, их засвар хийсэн тухай заавал тэмдэглэнэ/

№	Огноо	Засвар хийх болсон шалтгаан	Сэргээн засварласан эд анги		Шинээр сольсон эд анги		Засварын ажлыг гүйцэтгэсэн засварчин
			нэр	тоо	нэр	тоо	
1.							
2.							
3...							

ДОЛОО.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭГЭЭ

№	Огноо	Техникийн байдал	Хяналтын улсын байцаагч /гарын үсэг, тамга/	Тэмдэглэл
1.				
2.				
3...				

НАЙМ.ХУВИЙН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙГ ШАЛГАСАН ТЭМДЭГЛЭЛ

№	Огноо	Өгсөн зөвлөгөө	Шалгасан, зөвлөгөө өгсөн хүний албан тушаал, нэр /гарын үсэг/
1.			
2.			
3...			


ЕС.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЛИЙН БҮРТГЭЛ, ӨӨРЧЛӨЛТ


Тусгай зөвшөөрлийн дугаар	Олгосон, дуусах хугацаа	УЗТХ-ийн жолоочийн мэдээлэл	Үнэмлэхийн дугаар	Өөрчлөлт орсон мэдээлэл

Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын гуравдугаар хавсралт

Усан замын тээврийн хэрэгслийн улсын дугаар, түүнийг тэмдэглэх хэмжээ, байршил

1. Усан замын тээврийн хэрэгслийн улсын дугаар нь төрийн далбаа болон харьяалагдах улс, тухайн орон нутгийн нэрийг илэрхийлсэн үсэг, усан замын тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн дарааллаар нь олгосон цифрээс бүрдэнэ. Цифр нь 01-ээс эхлэх ба цаашид бүртгэгдсэн усан замын тээврийн хэрэгслийн тооноос хамаарч аравт, зуут, мянгатын оронд шилжих маягаар дугаарлагдана.

Жишээ нь:  M01XӨ гэсэн улсын дугаарын М үсэг нь Монгол Улс, 01- хамгийн эхэнд бүртгүүлсэн усан замын тээврийн хэрэгслийн дугаар, ХӨ- Хөвсгөл аймаг.



2. Усан замын тээврийн хэрэгсэлд олгосон улсын дугаарыг тухайн тээврийн хэрэгслийн хамрын хоёр хажуу талд, түүний хошуун талаас,

их биеийн уртын $\frac{1}{4}$ -тэй тэнцэх хэмжээний зайд, их биеийн дэвсгэр өнгөнөөс тод ялгарах өнгийн будгаар буюу зориулалтын наалт нааж тэмдэглэнэ.

Улсын дугаарын үсэг, тооны өндөр 150 мм-ээс багагүй, өргөн нь 100 мм, зураасны өргөн 15-20 мм байх ба дармал том үсгээр бичнэ. Үсгүүд нь тоонуудаасаа тухайн үсгийн буюу тооны өргөнтэй тэнцүү хэмжээгээр тусгаарлагдсан байна.

Усан замын тээврийн хэрэгслийн зохион бүтээгдсэн онцлогоос хамаарч дээр дурдсан шаардлагыг биелүүлэх боломжгүй тохиолдолд улсын дугаарын хэмжээ 7.6 см-ээс багагүй өндөртэй байх ба дугаар тэмдэглэх байршлыг усан замын тээврийн хяналтын улсын байцаагчаас зөвлөгөө авч тодорхойлно.

*Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх,
тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын дөрөвдүгээр
хавсралт*

**УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН
ҮЗЛЭГ, ОНОШЛОГООНЫ ХУУДАС**

Дугаар:

Огноо: 20.../ .../

Ээлжит

Ээлжит бус

Анхан шатны

**а.Өмчлөгч, эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн талаарх
мэдээлэл**

Иргэн, ААН, байгууллагын нэр:	
Регистрийн дугаар:	
Харьяалал /аймаг, сум, хот, дүүрэг/	
Хаяг:	
Холбоо барих /утас, цахим шуудангийн хаяг/	

б.Усан замын тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолт

Улсын дугаар		Их биеийн материал	
Нэр		Их биеийн урт,өргөн (м)	
Марк		Ангилал	
Зориулалт		Хажуу хавирганы өндөр (м)	
Үйлдвэрлэсэн он, улс		Хажуу хавирганы уснаас дээших хамгийн дээд өндөр (м)	
Монгол Улсад орж ирсэн огноо		Суулт (м)	
Даац (т)		Байршил (газар, орон нутгийн нэр)	
Зорчигчийн багтаамж (хүн)		Багийн бүрэлдэхүүний тоо	

в.Хөдөлгүүрийн тоо

Үндсэн		Нэмэлт	
Төрөл		Төрөл	
Хүчин чадал (м/хүч)		Хүчин чадал (м/хүч)	
Дугаар		Дугаар	
Такт		Такт	

г.Техникийн хяналтын үзлэг, оношлогоо

Д/д	Үзүүлэлтүүд	Үнэлгээ тийм/үгүй	Тайлбар
1	Зориулалтын дагуу ашиглаж байгаа байдал (үйлдвэрлэгчээс тогтоосон зориулалт)		
2	Их биеийн байдал (ерөнхий байдлыг үнэлэх)		
3	Жолоодлогын тоног төхөөрөмж (бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)		
4	Зангуу буулгах, татах тоног төхөөрөмж, уяа оосор (бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)		
5	Хөвөх чанар, тогтвортой байдал, үл живэх чанар (ерөнхий байдлыг үнэлэх)		
6	Хөдөлгүүрийн хүчин чадлын дээд хязгаар (техникийн баримт бичгээр тогтоосон)		
7	Хөдөлгүүрийн ажиллагаа (ялгарч буй утааны бохирдол байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэх)	CO2 CO HC	
8	Хөдөлгүүрийн аваарын унтраалга Kill cord – Emergency Cut off Switch (бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)		
9	Шатахууны савны битүүмжлэл (шатах тослох материал алдагдаж буй эсэх)		
10	Цахилгааны тоног төхөөрөмж, хэрэгслүүд (бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)		
11	Ёроолын ус шавхагч насосын ажиллагаа (бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)		
12	Гэрэлтүүлэг, дохионы хэрэгслүүд (нэр төрөл, тоо ширхэг, бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)		
13	Механик тоног төхөөрөмж, хэрэгслүүд (ерөнхий байдлыг үнэлэх)		
14	Холбоо, радио холбооны хэрэгслүүд (GPS төхөөрөмж, төрөл марк, ажиллагааны бүрэн бүтэн байдал)		
15	Галын аюулаас урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмж, хэрэгслүүд (бүрэн бүтэн байдал, тоо ширхэг, ашиглалтын хугацаа)		
16	Аврах хэрэгслүүд (аврах завь, онцгой үед ашиглах авран хамгаалах хэрэгслийн нэр төрөл, тоо ширхэг, бүрэн бүтэн байдал, ашиглалтын шаардлага хангасан эсэхийг үнэлэх)		
17	Хангалтын эд зүйлсийн иж бүрдэл (анхан шатны тусламжийн хэрэгсэл, тоо ширхэг, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох)		
Ерөнхий үнэлгээ, дүгнэлт (тэнцсэн, тэнцэхгүй)			

Аялах бүс, нөхцөл:		
Давлагааны өндрийн дээд хязгаар (метр)		
Эргээс холдох алслалт (метр)		
Хөдөлгүүрийн хүчин чадлын дээд хязгаар (м/хүч)		
Даацын дээд хязгаар (тн)		

Техникийн хяналтын

үзлэг хийсэн / /
(гарын үсэг) (овог нэр, албан тушаал)

Өмчлөгч (эзэмшигч) / /
(гарын үсэг) (овог нэр, албан тушаал)

*Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх,
тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын тавдугаар
хавсралт*

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Дугаар:
Огноо: 20.../ .../ Танаа
/Өргөдөл хүлээн авагч байгууллага/

Өргөдлийн агуулга /Холбогдох утгыг сонгоно уу/		
<input type="checkbox"/> 1. Шинээр бүртгүүлэх	<input type="checkbox"/> 2. Бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийх	
<input type="checkbox"/> 3. Гэрчилгээг нөхөн олгох	<input type="checkbox"/> 4. Хөдөлгүүр өөрчилсөн	
Өргөдөл гаргагч иргэн, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл		
1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр:	2. Харьяалал /аймаг, сум, хот, дүүрэг/	3. Регистрийн дугаар:
4. Байнгын оршин суугаа хаяг:	5. Холбоо барих утас: _____	
	6. Цахим шуудангийн хаяг: _____	
Өмч хүлээн авагч иргэн, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл /Зөвхөн бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийх тохиолдолд бөглөнө/		
1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр:	2. Харьяалал /аймаг, сум, хот, дүүрэг/	3. Регистрийн дугаар:
4. Байнгын оршин суугаа хаяг:	5. Холбоо барих утас: _____	
	6. Цахим шуудангийн хаяг: _____	
Усан замын тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолт		
1. Марк: _____	6. Үйлдвэрлэсэн: _____ он _____ улс _____	
2. Даац _____ кг	7. Ангилал: <input type="checkbox"/> жижиг <input type="checkbox"/> дунд	
3. Зорчигчийн тоо _____	<input type="checkbox"/> бага <input type="checkbox"/> том	
4. Их биеийн хэмжээ: Урт _____ м, өргөн _____ м	8. Багийн бүрэлдэхүүний тоо _____	
5. Их биеийн материал _____		
9. Оноосон нэр:	10. Зориулалт:	11. Үйл ажиллагаа явуулах газар, орон нутгийн нэр:
Хөдөлгүүрийн талаарх мэдээлэл		
1. Үндсэн хөдөлгүүр: марк _____ хүчин чадал _____ м.х дугаар _____ төрөл _____		
2. Нэмэлт хөдөлгүүр: марк _____ хүчин чадал _____ м.х дугаар _____ төрөл _____		

Хөдөлгүүр өөрчлөгдсөн тухай тэмдэглэл /Зөвхөн хөдөлгүүрийг өөрчилсөн тохиолдолд бөглөнө/	
марк _____	хучин чадал _____ м.х дугаар _____ төрөл _____

Өргөдөл гаргасан:

/..... /

Өргөдөл хүлээн авсан тухай тэмдэглэл /Бүртгэгч байгууллагын албан хаагч бөглөнө/				
Өргөдлийн дугаар:		Өргөдөл хүлээн авсан		
Огноо:	Нэр	Албан тушаал	Гарын үсэг	
Өргөдөл хавсаргасан баримт бичиг		шинээр	шилжилт хөдөлгөөн	нөхөн олгох
Иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн цахим лавлагаа				
Усан замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн техникийн дагалдах баримт бичиг				
Импортоор оруулж ирсэн бол гаалийн бүрдүүлэлтийн мэдүүлэг, эсхүл бүрдүүлэлт хийснийг нотолсон гаалийн байгууллагын тодорхойлолт				
Усан замын тээврийн хэрэгслийг Монгол Улсад үйлдвэрлэж, угсарсан бол түүнийг нотолсон баримт бичиг				
Усан замын тээврийн хэрэгслийг техникийн үзлэг, оношлогоонд оруулсан баримт бичиг				
Улсын тэмдэгтийн хураамж болон бусад холбогдох татвар, хураамж төлсөн баримт				
Хуульд заасан даатгалд даатгуулсан баримт				
Иргэн, хуулийн этгээдийн хооронд байгуулсан өмчлөлөө шилжүүлсэн гэрээ /нотариатаар гэрчлүүлсэн/				
Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ				
Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүр өөрчлөгдсөн тохиолдолд тухайн өөрчлөлт нь стандартын шаардлага хангаж байгааг нотолсон техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт, хүсэлт				
Гэрчилгээг нөхөн олгохыг хүссэн иргэний өргөдөл, хуулийн этгээд бол албан бичиг				
Үрэгдүүлсэн гэрчилгээг хүчингүйд тооцсон тухай өдөр тутмын сонинд зарлуулсан баримт, сонины зарын хуулбар				
Хавсралт хуудасны тоо				

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 04

Жаргалант

ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит Арвангуравдугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Сумын нутаг дэвсгэрт мөрдөгдөх “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тооцох”-г 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамж, нэгжийн үнэ тарифыг мөрдөж, албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдэд дагаж мөрдүүлэн, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг сумын Засаг дарга (Б.Гомбодорж)-д даалгасугай.

3.Уг тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (П.Ганпүрэв)-т даалгасугай

4.Энэхүү тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн улсын санд бүртгүүлж Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсний дараа дагаж мөрдсүгэй.

5.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Д.ДАШДАВАА

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн
ээлжит арвангуравдугаар хуралдааны
дөрөвдүгээр тогтоолын хавсралт*

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ

Хүснэгт 1

№	Ангилал	Төлбөр ноогдуулах хугацаа, нэгж /сард/	Төлбөрийн хэмжээ /төгрөг/
1	Худалдаа үйлчилгээний газар, зоогийн газар, үсчин гоо сайхан, эмийн сан	1-3 хүртэлх ажиллагсадтай бол сард	20000
		4-15 хүртэлх ажиллагсадтай бол сард	50000
2	Аялал жуулчлалын газар, хүүхдийн зуслан	Сард	100000
3	Төсөвт байгууллага	Сард	20000
4	Уул уурхайн ААН	Сард	500000
5	Аж ахуйн нэгж улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг	Сард	100000
6	Айл өрх/ иргэн	Сард	1000
7	ААН-байгууллага байнгын үйл ажиллагаа явуулдаг/ цахилгаан, шатахуун түгээх станц, банк/	Сард	30000

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 05

Жаргалант

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

“Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай” сумын Засаг дарга Б.Гомбодоржийн мэдээллийг хэлэлцээд “Малын тоо толгойн албан татварын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, “Татварын ерөнхий хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.4, “Төсвийн тухай” хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8, “Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1-ийн “д” заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Арвангуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Малчин, мал бүхий этгээдийн нэг толгой малд ногдуулах албан татварын хэмжээ “0” төгрөг байх малын тооноос давсан малын толгой тутамд ногдуулах албан татварын хэмжээг дор дурдсанаар тогтоосугай.

Үүнд:

Тэмээ – 0 төгрөг

Адуу – 1000 төгрөг

Үхэр – 500 төгрөг

Хонь – 300 төгрөг

Ямаа – 500 төгрөг

2. Малчин, мал бүхий этгээдийн нэг толгой малд ногдуулах албан татварын хэмжээ “0” төгрөг байх малын төрөл, тоог дор дурдсанаар тогтоосугай.

Үүнд:

Тэмээ-0 хүртэл толгой

Адуу-10 хүртэл толгой

Үхэр – 10 хүртэл толгой

Хонь - 30 хүртэл толгой

Ямаа – 20 хүртэл толгой

3.Малын тоо толгойд ногдуулсан албан татварыг “Малын тоо толгойн албан татварын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан хугацаанд төлүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

4.“Малын тоо толгойн албан татварын тухай” хууль болон энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, малын тоо толгойн албан татварын орлогыг сумын жил бүрийн төсөвт тусган батлуулах, сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэн “Төсвийн тухай” хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасан зориулалтаар зохих журмын дагуу зарцуулахыг сумын Засаг дарга (Б.Гомбодорж)-д даалгасугай.

5.“Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай” тогтоолыг Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэн мөрдүүлэх арга хэмжээ авахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (П.Ганпүрэв)-д даалгасугай.

6.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 5 дугаар сарын 24 өдрийн 02 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

7.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ДАШДАВАА

БОЛОВСРОЛЫН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 3 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар А/79

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 26.2, 27.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа суралцагчийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нарт даалгасугай.

3.Тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд тус тус үүрэг болгосугай.

3.1.Журмын хэрэгжилтийг арга зүйн удирдлагаар хангаж, өмчийн бүх хэлбэрийн хүүхдийн цэцэрлэгийн удирдах ажилтан, багш нарт сургалт, зөвлөн туслах ажлыг үе шаттай зохион байгуулж, үр дүнг 2026 оны хоёрдугаар улиралд багтаан танилцуулахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт;

3.2.Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх даалгаврын сан бүрдүүлж, үнэлгээний ажлыг арга зүйн удирдлагаар хангаж ажиллах, үнэлгээний үр дүнг цахим системд байршуулан шинжилгээ хийх программ хангамжийг хөгжүүлэх санал боловсруулж, 2026 оны 5 дугаар сард багтаан танилцуулахыг Цахим боловсрол, статистик, мэдээллийн хэлтэс (Т.Бат-Эрдэнэ), Боловсролын үнэлгээний төв (Э.Цэрэнцоодол)-д;

3.3.Журмын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг танилцуулахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Л.Төгсбаяр)-т.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны “Журам батлах тухай” А/280 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

П.НАРАНБАЯР

*Боловсролын сайдын 2026 оны 3 дугаар сарын 11-ний
өдрийн А/79 дүгээр тушаалын хавсралт*

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД
ХАМРАГДАЖ БАЙГАА СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖИЛ БОЛОН
СУРГУУЛЬД БЭЛТГЭГДСЭН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Өмчийн бүх хэлбэрийн хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/-т үндсэн болон хувилбарт сургалтад хамрагдаж байгаа суралцагчийн хөгжил болон ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид элсэх суралцагчийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэхэд энэхүү журмыг баримтална.

1.2.Суралцагчийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний зорилго нь тэдний бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжилд гарч байгаа ахиц өөрчлөлтийг илрүүлэх, сургуульд суралцахад шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагын түвшнийг тогтооход чиглэгдэнэ.

1.3.Үнэлгээнд суралцагчийн нас, хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээг харгалзсан, хүүхдийн хөгжлийг дэмжсэн, нотолгоонд суурилсан, оролцоог тэгш хангасан, ялгаварлан гадуурхалт, хөндлөнгийн нөлөөллөөс ангид байх зарчмыг баримтална.

1.4.Үнэлгээний үр дүн нь суралцагчийн хөгжлийн түвшин, ялгаатай хэрэгцээг харгалзан сургалт, үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх үндэслэл болно.

1.5.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг үнэлгээнд хамруулахад энэхүү журам болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан холбогдох журам, аргачлалыг баримтална.

Хоёр.Суралцагчийн хөгжлийн үнэлгээ

2.1.Суралцагчийн хөгжлийн үнэлгээг сургалт, үйл ажиллагааны явцад тэдний бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжилд гарч байгаа ахиц өөрчлөлт, үр дүнг илрүүлж, тэдэнд үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох зорилгоор хийнэ.

2.2.Суралцагчийн хөгжлийн үнэлгээ нь гараа (оношлох)-ны, явцын, үр дүнгийн гэсэн гурван төрөлтэй байна.

2.3.Суралцагчийн хөгжлийн түвшин, ялгаатай хэрэгцээг тодорхойлж, сургалт, үйл ажиллагааг төлөвлөх зорилгоор гарааны үнэлгээг багш хичээлийн жилийн эхэнд хийнэ.

2.4.Бага бүлгийн суралцагчийн гарааны үнэлгээнд Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.5-д заасан хөтөлбөрийг баримтална.

2.5. Дунд, ахлах, бэлтгэл бүлгийн суралцагчийн гарааны үнэлгээнд өмнөх хичээлийн жилийн үр дүнгийн үнэлгээний мэдээллийг ашиглана.

2.6. Явцын үнэлгээ нь сургалт, үйл ажиллагааны явцад суралцагчдад тулгамдаж байгаа асуудлыг илрүүлж дэмжлэг үзүүлэх, суралцагчийн хөгжил, төлөвшилд гарч байгаа ахиц өөрчлөлтийг тодорхойлоход чиглэнэ.

2.7. Суралцагчдад сургалт, үйл ажиллагааны явцад тулгамдаж байгаа асуудлыг илрүүлж, дэмжлэг үзүүлэх ажлыг доор дурдсаны дагуу хийнэ:

2.7.1. тухайн сургалт, үйл ажиллагааны хүрэх үр дүн, дасгал, даалгаврын зааврыг суралцагч бүр ойлгосон эсэхийг ажиглан, дэмжлэг шаардлагатай суралцагчдад нэмэлт тайлбар өгөх, чиглүүлэх;

2.7.2. сургалт, үйл ажиллагааны явцад суралцагчийн гүйцэтгэх явцыг ажиглан ялгаатай дэмжлэг үзүүлэх, урамшуулах;

2.7.3. өөрийн болон бусдын дасгал, даалгаврын гүйцэтгэл, бүтээлийг хэлэлцэх, дүгнэлт өгөх, сайн тал, алдааг олж харах, саналаа хуваалцахад туслах;

2.7.4. сургалт, үйл ажиллагааны үед тулгарч байгаа бэрхшээлийг олж харах, буруу ойлголтыг залруулах, арга замыг чиглүүлэх, тухайн нөхцөлд тохирсон заавар зөвлөгөө өгөх;

2.7.5. тухайн сургалт, үйл ажиллагаагаар суралцагч ямар үр дүнд хүрсэн, хэрхэн сайжруулах, гүйцээх талаар тайлбарлах, ярилцахад дэмжлэг үзүүлэх.

2.8. Багш сургалт, үйл ажиллагааны явцад доор дурдсаны дагуу баримт нотолгоог бүрдүүлж, түүнд үндэслэн журмын 2.8.4-д заасан ажиглалтын хуудасны дагуу суралцагч бүрийн ахицыг илрүүлнэ:

2.8.1. суралцагчийн суралцах үйл явцыг ажиглаж, тэмдэглэл хөтлөх;

2.8.2. суралцагчийн онцлогоос хамааран тодорхой зорилгын дагуу шаардлагатай тохиолдолд ярилцлага хийж, тэмдэглэл хөтлөх;

2.8.3. сургалт, үйл ажиллагааны үр дүнд гарсан суралцагчийн хөгжлийн ахицыг илэрхийлэх баримт нотолгоо цуглуулж, хувийн хавтас бүрдүүлэх;

2.8.4. тодорхой хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн суралцахуйн үр дүнд тулгуурлан “ажиглалтын хуудас”-ыг боловсруулж, мэргэжлийн багш нарын бүлгээр хэлэлцүүлэн сайжруулах;

2.8.5. холбогдох баримт нотолгоонд үндэслэн журмын 2.8.4-д заасан ажиглалтын хуудасны дагуу суралцагч бүрийн ахицыг илрүүлэх.

2.9. Үр дүнгийн үнэлгээ нь хичээлийн жилийн явцад цуглуулсан баримт, нотолгоонд дүн шинжилгээ хийж, суралцагч бүрийн хөгжлийн түвшнийг тодорхойлоход чиглэнэ.

2.10.Багш үр дүнгийн үнэлгээг энэхүү журмын хавсралтад заасан “Суралцагчийн хөгжлийн үнэлгээ”-ний шалгуурыг баримтлан хийж, суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн түвшнийг доор дурдсаны дагуу тодорхойлно.

80.0 ба түүнээс дээш хувьтай бол “Хангалттай эзэмшиж байна”;

50.0-79.0 хувьтай бол “Ахиж байна”;

49.0 ба түүнээс доош хувьтай бол “Хөгжиж байна”.

2.11.Үр дүнгийн үнэлгээг тухайн хичээлийн жилийн 5 дугаар сард багтаан хийж, бүлгийн хэмжээнд багш, цэцэрлэгийн хэмжээнд арга зүйч (эрхлэгч) тус тус нэгтгэнэ.

2.12.Үр дүнгийн үнэлгээний дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч баталгаажуулж, холбогдох мэдээллийг боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагын цахим системд бүлгийн багш оруулна.

2.13.Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш нь үр дүнгийн үнэлгээний дүн, дүгнэлтэд шинжилгээ хийж, дараагийн хичээлийн жилийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтөд тусган хэрэгжүүлнэ.

2.14.Багш нь суралцагчийн хөгжилд гарсан ахиц өөрчлөлт, хүрсэн үр дүнг тухайн суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчид танилцуулж, зөвлөгөө өгч, хамтран ажиллана.

2.15.Бэлтгэл бүлгийн багш ерөнхий боловсролын сургуульд элсэн суралцах суралцагчийн давуу тал, хөгжлийн онцлог мэдээллийг багтаасан дүгнэлт бүхий илгээх хуудсыг бэлтгэж, цэцэрлэгийн эрхлэгч баталгаажуулан, суралцагчийн хувийн хавтаст хавсаргана.

Гурав.Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ

3.1.Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ нь тухайн онд зургаан нас хүрэх суралцагчийн сургуульд элсэн суралцахад шаардлагатай мэдлэг, чадвар, төлөвшлийн түвшнийг тогтооход чиглэнэ.

3.2.Суралцагчийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг аймаг, нийслэлийн Боловсролын газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулна.

3.3.Ажлын хэсэг нь цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, эцэг эх, асран хамгаалагч, ерөнхий боловсролын сургуулийн бага боловсрол хариуцсан сургалтын менежер, бага ангийн багшийн оролцоог тус тус хангасан байна.

3.4.Суралцагчийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэхэд энэхүү журмын хавсралтад заасан “Суралцагчийн хөгжлийн үнэлгээ”-ний шалгуурыг баримтална.

3.5.Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг энэхүү журмын 3.11.2-д заасан удирдамжийн дагуу жил бүрийн 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулна.

3.6.Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээнд тухайн жилд

ерөнхий боловсролын сургуульд элсэн суралцах суралцагчийг бүрэн хамруулна.

3.7.Бүлгийн багш сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний мэдээллийг тухай бүр энэхүү журмын 2.12-д заасан цахим системд оруулна.

3.8.Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг зохион байгуулж дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор үнэлгээний тайланг аймаг, дүүргийн Боловсролын газарт хүргүүлнэ.

3.9.Цэцэрлэгийн эрхлэгч сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ зохион байгуулах орчин, нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

3.10.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана.

3.11.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага нь сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг зохион байгуулах хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.11.1.сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний даалгаврын санг бүрдүүлж, хөгжүүлэх;

3.11.2.сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг зохион байгуулах удирдамж, үнэлгээний даалгавар, бусад арга хэрэгслийг жил бүрийн 4 дүгээр сард багтаан баталж, аймаг, нийслэлийн Боловсролын газарт хүргүүлэх;

3.11.3.сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ зохион байгуулах арга зүйн сургалт явуулах;

3.11.4.энэхүү журмын 2.12-д заасан цахим системийн бэлэн байдлыг хангаж, үнэлгээний явцад хэвийн ажиллах нөхцөл бүрдүүлэх.

Дөрөв.Үнэлгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, ашиглах

4.1.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага энэхүү журмын 3.7-д заасан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүн, тайланг жил бүрийн 9 дүгээр сард багтаан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагад тус тус хүргүүлнэ.

4.2 Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах ажлыг зохион байгуулна:

4.2.1.энэ журмын 4.1-д заасан үр дүн, тайланд үндэслэн багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих зөвлөмж боловсруулж, аймаг, нийслэлийн Боловсролын газар, багшийн хөгжлийг дэмжих үндэсний/бүсийн төвд жил бүрийн 11 дүгээр сард багтаан хүргүүлнэ;

4.2.2.багшийн хөгжлийг дэмжих үндэсний/бүсийн төвтэй

хамтран энэ журмын 4.2.1-т заасан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд аймаг, нийслэлийн Боловсролын газарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

4.2.3.багшийг дадлагажуулах үйл ажиллагааны жишиг хөтөлбөрт суралцагчийн хөгжлийн үнэлгээний талаарх агуулгыг тусган хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.

4.3.Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нь үр дүнгийн үнэлгээний дүн, дүгнэлтэд шинжилгээ хийж багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлон, цэцэрлэгийн хэмжээнд багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулна.

4.4.Аймаг, нийслэлийн Боловсролын газар нь дараах ажлыг зохион байгуулна:

4.4.1.тухайн орон нутгийн хэмжээнд суралцагчийн хөгжлийн үр дүнгийн үнэлгээ болон сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний дүнд шинжилгээ хийж, багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг сайжруулах;

4.4.2.энэ журмын 4.2-т заасан байгууллагаас хүргүүлсэн зөвлөмжид үндэслэн багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах.

4.5.Суралцагчийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний үр дүн, дүгнэлтийг ерөнхий боловсролын сургуулийн захирал, бага боловсролын сургалтын менежер, нэгдүгээр анги удирдсан багш энэ журмын 2.12-т заасан цахим системээс танилцаж, сургалт, үйл ажиллагаандаа тусган ажиллана.

Тав.Бусад

5.1.Суралцагчийн хувийн хавтсыг цэцэрлэгээс шилжих болон ерөнхий боловсролын сургуульд элсэх үед эцэг эх, асран хамгаалагчид хүлээлгэн өгнө.

5.2.Эцэг эх, асран хамгаалагч энэхүү журмын 5.1-д заасан хувийн хавтсыг ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багшид танилцуулна.

5.3.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын зөвшөөрөлгүйгээр суралцагчийн хөгжлийн түвшинг үнэлэх аливаа шалгалт, судалгаа авахыг хориглоно.

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа суралцагчийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журмын хавсралт

СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Үнэлгээний хүрээ	№	Шалгуур (I түвшин)
Мэдлэг	1	Чанаж болгоогүй хүнсийг идэж болохгүйг мэддэг.
	2	Хүрээлэн байгаа орчноос болгоомжлох зүйлсийг таньдаг.
	3	Зурагт номоос танил эд юмсыг нэрлэдэг.
	4	Орчныхоо ургамал, амьтнаас заримыг нь нэрлэдэг.
	5	Цаг агаарын үзэгдлийг таньж нэрлэдэг.
	6	Өөрийн нэр, нас, биеийн эрхтнээ нэрлэдэг.
	7	Үндэсний хувцас (дээл, гутал, малгай)-ыг нэрлэдэг.
	8	Үндсэн гурван өнгийг нэрлэдэг.
	9	Тоглоом, юмсын заасан байршил (дээр, доор)-ыг нэрлэдэг.
	10	Болно, болохгүйг ойлгодог.
	11	Бусдын нүүрний хувирал, гарын дохио, дуу авиа, үгээр илэрхийлсэн харилцааг ойлгодог.
Чадвар	12	1-2 саадыг сүлжиж алхдаг (10 метр зайд).
	13	Хоорондоо 20 см зайтай байрлуулсан зураасны дундуур шулуун чиглэлээр гүйдэг.
	14	20 см зайтай зураасны хооронд дөрвөн хөллөж мөлхдөг.
	15	Хоёр хөл дээрээ үсэрч буудаг.
	16	Тоглоом, юмс (бөмбөг, базсан цаас гэх мэт)-ыг тодорхой чиглэлд (урагш, дээш гэх мэт) шидэж дамжуулдаг.
	17	Гар, нүүр, шүдээ угаах, хоолой амаа зайлах үйлийг бусдын дэмжлэгтэйгээр хийж чаддаг.
	18	Хоолны хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэдэг.
	19	Бусдын яриаг сонсож ойлгоод, үг, үйлдэл, дохио зангаагаар харилцдаг.
	20	Энгийн өгүүлбэрийг дуурайн хэлдэг.
	21	Авиа, үгийг сонсоод давтан хэлдэг.
	22	Ярилцах болон тоглох явцад асуулт асуухыг оролддог.
	23	3 хүртэлх тоглоом, юмсыг тоолдог.
	24	Том, жижгийг ялгадаг.
	25	Юмсыг нэг ижил шинжээр нь ангилдаг.
	26	Харандаагаар мөр, зураас гаргадаг.
	27	Бусдын үйлийг ажиглаж дуурайдаг.
	28	Бэлдэц дүрс ашиглан бусдын дэмжлэгтэй наамал хийдэг.
	29	Хэв ашиглан хэлбэр гаргадаг.
	30	Тоглоом, эд юмсыг бусдын дэмжлэгтэй өрдөг.

Төлөвшил	31	Өөрийн хэрэгцээ, биеийн зарим мэдрэмжээ нүүрний хувирал, биеийн хөдөлгөөн, үгээр илэрхийлдэг.
	32	Хүн, амьтны дуу авиаг сонсоод ялгадаг.
	33	Дуу, хөгжмийн хэмнэлийг хөдөлгөөн (алга таших, өвдөг цохих гэх мэт)-өөр илэрхийлдэг.
	34	Бусдын бүтээлийг ажиглаж сонирхдог.
	35	Хогийг хогийн саванд хийдэг.
Төлөвшил	36	Өөр хэн нэгэн аргадах (уурлаж тавгүйтсэн, уйлсан үед)-д тайвширдаг.
	37	Хэрэглэсэн эд зүйл, тоглоомоо хураадаг.

СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Үнэлгээний хүрээ	№	Шалгуур (II түвшин)
Мэдлэг	1	Гэмтэж болзошгүй үйлдлийг ойлгодог.
	2	Хоорондоо хамааралтай хоёр юмыг таньдаг.
	3	Орчиндоо байгаа зурган тэмдэглэгээ (гэрлэн дохио, гарц, ангид баримтлах дүрмийг харуулсан зураг гэх мэт)-г ойлгодог.
	4	Таван хошуу мал, гэрийн тэжээмэл амьтны үр төлийг нэрлэдэг.
	5	Үндэсний баяр ёслолын зарим үйл (золгох, бөх барилдах гэх мэт)-ийг нэрлэдэг.
	6	Дараалан байрлуулсан тоглоом, дүрс, юмсыг ажиглаж, зүй тогтлыг тайлбарладаг.
	7	Тоглоом, юмсын байршил (дотор, гадна)-ыг нэрлэдэг.
	8	Уран зураг, баримлын бүтээлд юу дүрсэлснийг нэрлэдэг.
Цадвар	9	Сэтгэл хөдлөлөө үг, эсвэл үйлдлээр илэрхийлдэг.
	10	Өөрийн хийх дуртай болон дургүй зүйлсээ илэрхийлдэг.
	11	Алхалтын үед гарын хөдөлгөөнийг өөрчилж (гараа алдлах, өргөх гэх мэт) гүйцэтгэдэг.
	12	Хоорондоо 15 см зайтай байрлуулсан зураасны дундуур шулуун чиглэлээр гүйдэг.
	13	Зааврын дагуу 2-3 саадыг сүлжиж мөлхдөг (10 метр зайд).
	14	Хоёр хөл дээрээ 5 хүртэлх зураас дээгүүр давж үсэрдэг.
	15	0.5-1 метр зайнаас шидсэн тоглоом, бөмбөг, эд юмсыг барьж авдаг.
	16	Зааврын дагуу өдөр тутмын хувийн ариун цэвэр сахих үйл (гар, нүүр, ам угаах)-ийг бие даан гүйцэтгэдэг.
	17	Жимс, хүнсний ногоог насанд хүрэгчдийн тусламжтай угаадаг.
	18	3-4 үгтэй өгүүлбэрийг давтаж хэлдэг.
	19	Сургалт, үйл ажиллагаанд оролцох, хамтдаа тоглох явцад асуулт асуудаг.
	20	Яриандаа өнгө, хэмжээ, тоо ширхэг заасан үгсийг хэрэглэдэг.
	21	5 хүртэл тоглоом, юмсыг тоолдог.

	22	Олон ба цөөн тооны тоглоом, юмсыг зааж хэлдэг.
	23	3 хүртэлх тооны юмсыг уртаар нь харьцуулдаг.
	24	Тоглоомыг 2 ижил шинж (өнгө, дүрс, хэмжээ гэх мэт)-ээр нь ангилдаг.
	25	Байгалийн үзэгдлийг ажиглаж, санаа бодлоо илэрхийлдэг.
	26	Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн талаар ярьдаг.
	27	Хялбар, ойлгомжтой заавар, дүрмийг ойлгож тайлбарладаг.
	28	Өөрийн дуртай зүйлээ зурж (зураас, толбо, дардас гэх мэт) дүрсэлдэг.
	29	Баримлын шавраар хоёр хэсгээс бүтсэн зүйлийг бие даан барьдаг.
	30	Бэлдэц дүрс ашиглан багшийн заавраар наамал хийдэг.
	31	Тоглоом, эд юмс (блоконт тоглоом, шагай, савх гэх мэт)-ыг бие даан бүтээл хийж, тайлбарладаг.
	32	Байгаль, эд юмсын дуу чимээг сонсоод ялгадаг.
	33	Тоглоом, хэрэглэгдэхүүн ашиглан аялгуунд тохируулж жигд хэмнэлээр дуугаргадаг.
	34	Хэмнэл, аянд тохирсон хөдөлгөөн хийдэг.
	35	Үлгэр, зохиолын танил дүрд тоглодог.
	Төлөвшил	36
37		Бусдад өөрийн санаачилгаар тусалдаг.
38		Бусадтай хамтран үйл ажиллагаанд оролцдог.
39		Энгийн заавар, дүрэм (ус хэмнэх, хогийг ангилж хаях гэх мэт)-ийг биелүүлдэг.
40		Тасалгааны ургамлын тоосыг арчиж, усалдаг.
41		Дууг бусадтай хамтран дуулдаг.

СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Үнэлгээний хүрээ	№	Шалгуур (III түвшин)
Мэдлэг	1	Эрүүл мэндэд тустай хоол, хүнсийг нэрлэдэг.
	2	Өөрийн болон бусдын биеийн хүрч болох, болохгүй хэсгийг мэддэг.
	3	Ухаалаг төхөөрөмжийг зохистой хэрэглэхийг мэддэг.
	4	Сэтгэл хөдлөл илэрхийлсэн 2-3 зургаас таатай, таагүй байгааг тайлбарладаг.
	5	Тайвшрахад туслах аргуудыг мэддэг.
	6	Хоёр зүйлийн хоорондын хамаарлыг тайлбарладаг.
	7	10 хүртэл цээжээр тоолдог.
	8	Чиглэл заасан үгсийн утгыг ойлгодог.
	9	Гэр бүлийн гишүүдийг нэрлэж, ажил мэргэжлийг нь хэлдэг.
Чадвар	10	Вандан сандал дээр тэнцвэрээ хадгалан алхдаг (Вандан сандлын өндөр нь 25 см, өргөн нь 20 см байна).
	11	5-6 саадыг сүлжиж гүйдэг (10 метр зайд).
	12	Өвдөг, тохойгоор 3-4 нуман доогуур мөлхдөг.
	13	10-15 см өндөрт байрлуулсан зүйлд үсэрч хүрдэг.

	14	Бөмбөгийг 1-1.5 метр зайд бие бие рүүгээ газарт ойлгон дамжуулдаг.
	15	Бусдын сануулгаар ариун цэврийг сахих үйлүүдийг бие даан гүйцэтгэдэг.
	16	Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ нь ямар аюул, эрсдэл байгааг анхааруулсныг тайлбарладаг.
	17	Өөрийн хэрэгцээ, чадах, чадахгүй, дуртай, дургүй зүйлсээ ярьдаг.
	18	Хийж болох, болохгүй үйлдлийн учир шалтгааныг тайлбарладаг.
	19	Үгийг сонсоод, урт ба богино авианы дуудлагыг ялган дуурайдаг.
	20	Тоглоом, юмсын 2-3 онцлог шинжийг тоочиж ярьдаг.
	21	Юмсын учир шалтгааныг өөрийн ойлгосноор тайлбарладаг.
	22	Ном, үлгэр, зохиолын гол санааг ойлгож, үйл явдлыг тайлбарладаг.
	23	5 хүртэлх тооны юмсыг оноож тоолдог.
	24	Дараалан байрлуулсан тоглоом, дүрс, юмсыг ажиглаж, зүй тогтлыг үргэлжлүүлдэг.
	25	Юмсыг хэмжээ (урт, хүнд)-гээр нь харьцуулдаг.
	26	Өглөө, өдөр, орой хийдэг үйл явдлыг харуулсан 4 зургийг зөв дараалалд оруулдаг.
	27	Тоглоом, эд юмсыг нэг шинжээр нь 4 хүртэлх хэсэгт ангилдаг.
	28	Дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрсийг ялган нэрлэдэг.
	29	Дүрс ба биетийг ялгадаг.
	30	Зурган зааварчилгааг ойлгож тайлбарладаг.
	31	Амьтдын амьдрах орчныг ялгадаг.
	32	Цаг агаарын байдалд тохируулан хувцаслаж, үйл ажиллагаанд оролцдог.
	33	Зураг бүтээлээ толбо, дардсаар чимэглэдэг.
	34	Хүн, амьтан, эд юмсыг өөрийн төсөөллөөр зохиомжлон барьдаг (баримлын шавар, элс, гурилан зуурмаг гэх мэт).
	35	Биет наамал урладаг.
	36	Өрж байгуулдаг, эвлүүлж, угсардаг тоглоом, савх, харандаа (байшин, барилга, гудамж талбай, тээврийн хэрэгсэл гэх мэт)-гаар зохион бүтээдэг.
	37	Дууг ая хэмнэлийн дагуу дуулдаг.
	38	Хэмнэлийн өөрчлөлтийг мэдэрч, хөгжмийн энгийн зэмсгээр тоглодог.
	39	Ая, хэмнэл солигдоход хөдөлгөөнөө тохируулдаг.
	40	Үлгэр зохиолын дүрээс сонгон онцлог шинжийг илэрхийлдэг.
Төлөвшил	41	Бусдын сэтгэлийн хөдөлгөөн өөр, өөр байдгийг мэдэн зохицож харилцдаг.
	42	Бусадтай тоглоом, наадгай, эд зүйлсээ хуваалцан хамтарч тоглодог.
	43	Өдөр тутмын үйл ажиллагаанд бие даан оролцдог.
	44	Харилцан ярианд идэвх санаачилга (тодруулах асуулт асуух, хариу өгөх, санаагаа илэрхийлэх)-тай оролцдог.
	45	Тасалгааны ургамлыг арчлахад оролцдог.
	46	Үндэсний тоглоом, наадгайгаар тоглодог (шагай, хөлөгт тоглоом зэрэг).

СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Үнэлгээний хүрээ	№	Шалгуур (IV түвшин)
Мэдлэг	1	Аюултай нөхцөлд (галаас хол байх, шатаар болгоомжтой явах гэх мэт) юу хийхийг мэддэг.
	2	Хүмүүсийн хоорондын харилцаа хэрхэн өрнөж байгааг ойлгодог.
	3	20 хүртэл цээжээр тоолдог.
	4	Долоо хоногийн гарагийг дарааллаар нь нэрлэдэг.
	5	Тоглоом, юмсын ижил ба ялгаатай шинжийг нэрлэдэг.
	6	Ургамлын ургалтад хэрэгтэй зүйлийг нэрлэдэг.
	7	Улирлын онцлог хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарладаг.
	8	Уран зураг, уран баримлын бүтээлийг хайрлан хамгаалахыг мэддэг.
Чадвар	9	Вандан сандал дээгүүр алхахдаа гарын хөдөлгөөн (гараа алдлах, өргөх гэх мэт)-ийг хослуулдаг.
	10	7-8 саадыг сүлжиж гүйдэг (10 метр зайд).
	11	Вандан сандал дээр элгээр гулсаж мөлхдөг.
	12	30 см өндөртэй тавцан дээрээс техникийн дагуу үсэрч буудаг.
	13	1.5-2 метр зайд байгаа хүүхдэд бөмбөгийг газарт ойлгож өгөх, газарт ойлгож өгсөн бөмбөгийг барьж авдаг.
	14	Сургалт, үйл ажиллагааны явцад тодорхой үйл, үйлдлийг хийж чадах, чадахгүй шалтгаанаа тайлбарладаг.
	15	Өөрийн хэрэгцээгээ илэрхийлдэг.
	16	Гэр бүлийн гишүүдээ танилцуулж, ажил хөдөлмөрт нь хэрхэн тусалдаг талаар тайлбарлан ярьдаг.
	17	Тайвшрахад туслах аргуудыг багшийн тусламжтай хэрэглэдэг.
	18	Нэрлэсэн үгийн эхэнд ба төгсгөлд орсон авиаг ялгадаг.
	19	Ном болон үлгэр, зохиол, болсон үйл явдлыг дэс дараатай тайлбарладаг.
	20	Үлгэр зохиолын төгсгөлийг өөрийн төсөөллөөр үргэлжлүүлэн зохиож ярьдаг.
	21	Өөрийн нэрийн дармал үсгийг дагуулж бичдэг.
	22	Ном болон үлгэр, зохиол, болсон үйл явдлыг дэс дараатай тайлбарладаг.
	23	10 хүртэлх эд юмсыг оноож тоолдог.
	24	Өгөгдсөн тооноос 20 дотор нэгээр нэмэгдүүлж, хорогдуулж тоолдог.
	25	10 хүртэлх тооны дарааллаас орхигдсон 1-2 тоог олдог.
	26	Нэг юмсын байрлалаар нөгөө юмсын байрлалыг тодорхойлдог.
	27	Юмсын хэмжээ (урт, хүнд, багтаамж)-гээр нь таамаглан харьцуулдаг.
	28	Юмсыг шинж чанараар нь бүлэглэн учрыг тайлбарладаг.
	29	Сэдвийн хүрээнд үйл явдал (байгалийн үзэгдэл, үлгэр гэх мэт)-ыг бүтээлчээр зохиомжлон зурдаг.

Төлөвшил	30	Баримлын шавар, байгалийн материал зэргээр сэдэвт баримал барьдаг.
	31	Өгөгдсөн сэдвийн хүрээнд наамал хийдэг.
	32	Эд зүйлсээр юмсыг зохиомжлон бүтээж, дүрслэлийг баяжуулдаг.
	33	Хөгжмийн энгийн зэмсгийг дуугаралтаар нь ялгаж нэрлэдэг
	34	Гарын дохионы дагуу дууны өндөрлөг, хурдыг зохицуулан дуулдаг.
	35	Хөгжмийн энгийн зэмсгээр аялгууны хэмнэлд нийцүүлэн хөгжимддөг.
	36	Хөгжмийн аялгуунд нийцсэн хөдөлгөөн хийдэг.
	37	Хувийн ариун цэвэр сахирын ач холбогдлыг ойлгож, тогтмол дагаж мөрддөг.
	38	Хоол хүнс, зууш бэлтгэхэд өөрийн хэмжээнд оролцож тусалдаг.
	39	Бохирдсон хоолны хэрэгслийг насанд хүрэгчидтэй хамтран цэвэрлэдэг.
	40	Ухаалаг төхөөрөмжийг хэрэглэх үедээ бусдын заавар, дүрмийг мөрддөг.
	41	Тоглоомын дүрэм баримтлан хамтран тоглодог.
	42	Гэр бүл, цэцэрлэг, анги, олон нийтийн газарт тогтсон дүрмийг баримталдаг.
	43	Өөрийнх нь үйлдэл бусдын сэтгэлийн хөдөлгөөнд нөлөөлж буйг мэдэж зохицон харилцдаг.
	44	Харилцан ярианд идэвх санаачилга (асуулт асуух гэх мэт)-тай оролцдог.
	45	Амьтдыг хайрлан хамгаалдаг.
	46	Бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг.
	47	Орчиндоо хариуцлагатай байж, хог ангилж, байгаль бохирдуулахгүй байх үйлийг хийдэг.
	48	Үндэсний соёл, зан заншлын зарим үйлийг бие даан болон найз нөхөдтэйгээ хамтран хийдэг.
49	Дүрийн зан чанарын талаар харилцан ярилцдаг.	

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 3 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар А/122

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн “Журам батлах тухай” 03 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 01/1262 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох талаарх Монгол Улсын дэд бүтцийн сайд (хуучин нэрээр)-ын 2002 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн “Журам батлах тухай” 150 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ч.УНДРАМ

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 3 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар А/61

Улаанбаатар
хот

ЖУРАМ ХҮЧИНГҮЙД ТООЦОХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2022 оны А/101 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1.Хэмжил зүйн тухай хуульд өөрчлөлт орж тухайн харилцааг зохицуулсан стандартууд батлагдсантай холбогдуулан Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны А/138 дугаар тушаалаар батлагдсан “Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлэх, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх журам”, 2021 оны А/154 дүгээр тушаалаар батлагдсан “Шалгалт тохируулгын ажилтны чадавхыг үнэлэх, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх журам”, 2021 оны А/154 дүгээр тушаалаар батлагдсан “Шалгалт тохируулгын ажилтны чадавхыг үнэлэх журам”, 2021 оны А/55 дугаар тушаалаар батлагдсан “Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын чадавхыг үнэлэх журам”-ыг тус тус хүчингүйд тооцсугай.

2.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан зохих арга хэмжээ авч ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын Хууль эрх зүй, хүний нөөцийг хэлтэс (С. Оюунцэцэг)-г үүрэг болгосугай.

ДАРГА

С.БАТБААТАР

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨМӨРБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 06

Төмөрбулаг
сум

ТОГТООЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IX хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэн батлагдаж шинэ нөхцөл байдал бий болсноор тухайн тогтоолын удирдлагын заалтын хуулийн зарим зүйл, заалт оновчгүй болсон, бусад хуулийн заалтыг алдаатай сонгож авсан байдал нь нийтийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх болсонтой холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн XIII дугаар хуралдааны “Төлбөрийн хувь, хэмжээг тогтоох тухай” 07 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Б.МӨНХТӨР

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 3 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар А/89

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төмөр замын тээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төмөр замын тээврийн тухай хууль (шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор “Аюултай бүсийн дэглэм”-ийг баталсан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Журам батлах тухай” А/146 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангаас хасалт хийлгэх арга хэмжээ авахыг Төмөр замын тээврийн бодлого зохицуулалтын газар (Х.Итгэлт)-т даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

ЗАЛРУУЛГА:

Эмхэтгэлийн 2026 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 7 дугаарын 984 дэх талд хэвлэгдэн гарсан ЭМС-ын 2026 оны Журам шинэчлэн батлах тухай А/27 дугаар тушаалын улсын бүртгэлийн огноог “2026 оны 3 дугаар сарн 24-ний өдөр” гэж, 1006 дахь талд хэвлэгдэн гарсан байгууллагын нэрийг “Сүхбаатар аймгийн” гэж залруулж байна.